



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/105/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Э.Энхцэцэг
Аудитор:		Цахим хаяг: enkhsetsege@audit.gov.mn
		Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.24 № 16/102

танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Х.ЦЭРЭНДОЛГОР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	4.0	5.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4.8	3.9
	Нийт хөрөнгийн дүн	8.8	9.8
	Нийт өр төлбөрийн дүн	-	0.3
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8.8	9.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8.8	9.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	74.8	74.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	71.7	74.3
	Үйл ажиллагааны үр дүн	3.1	0.6
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	3.1	0.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	74.5	75.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	72.5	75.8
	Үйл ажиллагааны ЦМГ	2.0	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	2.0	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5.7	8.9
	Тайлант оны үр дүн	3.2	0.6
	Эцсийн үлдэгдэл	8.9	9.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	68.0	66.5
	Урсгал зардал	68.0	66.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	68.0	66.5
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	68.0	66.5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь эдийн засаг нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлжээ.

Байгууллагын 2021 онд дэвшүүлсэн зорилт:

- Үндэсний бичгийн хэрэглээг сайжруулах;
- Угийн бичиг хөтлөлтийг бодитой нэмэгдүүлэх.

Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, төр, эдийн засаг, нийгмийн бодлогын үйл ажиллагааг үзүүлэх.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 10 мэдээлэл, огт мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1.8 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 1.4 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

- 1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.*
- 2. Машин тоног төхөөрөмжийн дансанд 0.2 сая, тавилга эд хогшлын дансанд 0.2 сая нийт 0.4 сая төгрөгийн элэгдлийг дутуу тооцсоныг залруулав.*
- 3. Хувь хүний орлогын албан татварын 0.8 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залруулав.*

Албан шаардлага

- 1. Олон нийтийн цагдаагийн урамшуулал 0.4 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас /210901/ зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.*

Зөвлөмж

1 Тодруулгатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3 дансны 10 ширхэг 4.1 сая төгрөгийн бүртгэлтэй үндсэн хөрөнгийг шийдвэрлээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, 31.3.3 “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Ашиглах боломжтой боловч ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг үнэлж бүртгэх, шаардлага хангаагүй хөрөнгийг акталж данснаас хасах арга хэмжээ авч ажиллах.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Эрдэнэ сумын ИТХ	5	1.8	3	1.4	-	-	1	0.4	1	-
	НИЙТ	5	1.8	3	1.4	-	-	1	0.4	1	-